

**АМЬ БАРИГЧ (СРОГЗИН) 5 ЭМИЙН СЭТГЭЛ ГУТРАЛД  
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ ТОГТООХ НЬ**

*Б.Одончимэг<sup>1</sup>, Т.Даваасамбуу<sup>2</sup>, Г.Сумъяахорол<sup>3</sup>, Р.Лхаасүрэн<sup>4</sup>, Ш.Болд<sup>5</sup>*

*<sup>1,2</sup>Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль,*

*<sup>3</sup>Эм судлалын хүрээлэн,*

*<sup>4</sup>Уламжлалт анагаах ухааны эрдэм судлалын хүрээлэн*

*E-mail: [odonchimegodnok@gmail.com](mailto:odonchimegodnok@gmail.com) phone number: 96029612*

**DETERMINING THE EFFECTS OF AMI BARIGCH (SROG'DZIN-) 5  
PRESCRIPTION ON DEPRESSION**

*Odonchimeg B<sup>1</sup>., Davaasambuu T<sup>2</sup>., Sumyakhorol G<sup>3</sup>., Lkhaasuren R<sup>4</sup>., Bold Sh<sup>5</sup>*

*<sup>1,2,3</sup>Mongolian University of Pharmaceutical Sciences*

*<sup>4</sup>Traditional Medical Research Institute*

**Abstract**

**Introduction:** Nowadays people are restricting their use of chemical drugs as much as possible, creating a growing need for a systematic study of the use of herbal, animal and mineral medicines at a new level through traditional and innovative methods. Based on the study of traditional national technologies, it is important to study and apply in practice the drugs and pharmaceutical ingredients that contain the most modern scientific achievements including cardiovascular drugs, obtained from ancient rare scriptures.

**Research materials and methods:**

Data collected from the Clinical Department of Stress-Related Mental Disorders of the National Center for Mental Health was the primary source for this study. Secondary sources included statistics on the hospital's website, internal reports of the organization, research related to health services, and legal documents.

**Research method:**

Serum cortisol levels were determined with a STATFAX-2100 ELISA (450 nm) according to the manufacturer's specific methodology ([www.melsin.com](http://www.melsin.com), Human Cortisol, ELISA KIT- CAT. NO:EKHU-0704).

The amount of cortisol in human serum was calculated as a linear quantitative assay by diluting 7.5 ug / L-90 ug / L in a standard working solution.

**Conclusion:** "Srog 'dzin-5" has a clinical effect of reducing serum cortisol by an average of 27.3%. The statistic ( $p < 0.01$ ) is likely to increase this percentage depending on the time taken. Clinical observations have shown that "Srog 'dzin-5" has pharmacological action against stress, depression and mental illness.

**Key word:** stress, depression, cortisol, Srog 'dzin-5

**Үндэслэл**

2015 оны байдлаар манай улсад хүн эмнэлгийн идэвхтэй хяналтад эмчлүүлж, хөдөлмөрийн чадвар алдсан нийт хүмүүсийн сэтгэц, зан үйлийн эмгэгтэй 22 мянга гаруй дотор сэтгэцийн эмгэгтэй хүмүүс 15%-ийг

эээлж байна. Эдгээр тоо баримт нь сэтгэцийн эмгэгээс сэргийлэх, уг эмгэгийг эмчлэх нь эрүүл мэндийн тулгамдсан асуудал болсныг харуулж буй бөгөөд уг асуудлыг шийдэхэд орчин цагийн анагаах ухааны эмчилгээ, сэргийлэлтийн аргаас гадна уламжлалт анагаах ухааны сэтгэцийн эмгэгийг эмчлэх талаар олон зуун жил хуримтлуулсан туршлага, өнөөг хүртэл хэрэглэсээр ирсэн аргын шинжлэх ухааны мөн чанарыг тогтоох талаар судалгаа хийж улмаар практикт хэрэглэх нь нэн чухал хэмээн үзэж байна<sup>1,2,3</sup>. Нөгөө талаар химийн гаралтай эмт бодисоос хүн төрөлхтөн аль болохоор татгалзах болсон өнөөгийн нөхцөлд ургамал, амьтан, эрдсийн гаралтай эмийн хэрэглээг уламжлал шинэчлэлийн аргаар шинэ түвшинд тогтолцоотой судлах шаардлага улам бүр нэмэгдэхийн зэрэгцээ үндэснийхээ уламжлалт технологийг судалсны үндсэн дээр хүний бие махбодод хамгийн нийцтэй орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилтыг шингээсэн эм, эм найрлага, түүний дотроос зүрх судасны эмийг эртний ховор нандин судар номоос олж тогтоон судалж практикт хэрэглэх нь хойшлуулшгүй хийх ёстой ажил болоод байна<sup>4</sup>.

Тиймээс бид уламжлалт анагаах ухааны сонгодог зохиолын дотроос өнгөрсөн зуунд практикт хэрэглэж байсан эмийн үйлдлийг тогтоох эмнэл зүйн ажиглалтын судалгаа хийхээр энэхүү сэдвийг сонгон авлаа.

### Судалгааны зорилго

Монголын уламжлалт анагаах ухааны сонгодог эмийн найрлага, эмчилгээний аргыг багтаасан судар дотроос сэтгэл гутралыг анагаах эмийг олж тогтоон, клиникийн судалгаа хийх.

### Судалгааны материал ба арга

- Судалгааны материал

СЭМҮТ-ийн Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг клиникийн тасгаас цуглуулсан

өгөгдөл нь уг судалгааны анхдагч эх сурвалж болсон. Эмнэлгийн веб сайтад байгаа статистик тоон мэдээ, байгууллагын дотоод тайлан, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой судалгаа, эрх зүйн баримт бичгүүдийг хоёрдогч эх сурвалж болгон авав.

Амь баригч-5 бэлдмэлийн<sup>5</sup> эмнэл зүйн ажиглалтын судалгаанд хамрагдсан хүмүүсээс бэлдмэл уулгаагүй үеийн цус авч цусан дах кортизолын хэмжээг ийлдсэнд нь тодорхойлсны дараа тус бэлдмэлийг 14 хоног уулгасан. Бэлдмэл уулгасны дараа судалгаанд оролцогчдоос цусны дээж авч цусны ийлдсэнд кортизолын хэмжээг тодорхойлж сэтгэл гутралын эсрэг үйлдлийг кортизолын бууралтаар үнэлсэн.

Хүний цусны ийлдсэн дэх кортизолын хэмжээг үйлдвэрлэгчийн тусгай арга аргачлал ([www.melsin.com](http://www.melsin.com), Human Cortisol, ELISA KIT- CAT.NO:EKHU-0704)-ын дагуу STATFAX-2100 маркын элайза багажаар (450 нм) тодорхойлсон. Хүний цусны ийлдсэн дэх кортизолын хэмжээг ажлын стандарт уусмалын 7.5 ug/L-90 ug/L шингэрүүлэлтээр тооны анализын шугаман чанараар тооцоолсон<sup>6</sup>.

### Elisa –Insert Ref.HES01-ийн аргачлал

#### Китний иж бүрдэл:


Нэг багц дах урвалж нь 96 үүртэй оношлуурт зориулагдсан болно.

Нэг багц урвалжын бүрдэл:

- Моноклон хэлбэрийн кортизолын цэвэршүүлсэн эсрэг бие наалдуулсан 96 үүр бүхий микроплет-12×8
- Кортизолын стандарт 7× (0.5 mL): Хүний цусны ийлдэснээс ялгасан кортизолын буфержуулсан уусмал
- 1× Cortisol-enzyme conjugate (1.2 mL)
- 1×Substrate (12 mL)
- 1×Stop solution (12 mL)
- 1×Wash buffer (25 mL)
- 1×Assay diluents (24 mL)

**Дээжний мэдээлэл**

Кортизолын энэхүү элайза китийг зөвхөн хүний ийлдэс болон сийвэнд л ашиглана. Цэвэршүүлсэн хуруу шилэнд (бүлэгнэлтийн эсрэг бодистой хамт, нэн даруй цусыг хурилдуулан ийлдсийг ялгах шаардлагатай) сийвэнг ялгана. Шинжилгээг яаралтай хийх боломжгүй бол -20<sup>0</sup>-д 1 сар, 2-8<sup>0</sup>С-д 5 хоног хүртэл хадгалж болно. Дээжийг хөлдөөсөн бол холигч ашиглан шинжилгээг гүйцэтгэнэ. Дахин хөлдөөж ашиглахаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Мөн цус цуглуулах болон ийлдсийг ялгах үед гемолиз, липемид, сийвэнг шарлуулах зэрэг нь туршилтын үр дүнд сөрөг нөлөөтэй (Зураг 1).



**Normal Hemolysed Lipemic Icteric**

Figure 1. Cortisol levels in human blood expressed as the dilution of the standard solution

Үр дүн: Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвд явагдаж буй Амь баригч-5

буюу Срогзон-5 эмийн бэлдмэлийн эмнэлзүйн ажиглалтын судалгаанд хамрагдсан хүмүүсийн цусны ийлдсэнд кортизолын хэмжээг тодорхойлов. Үр дүнгийн статистик боловсруулалтыг SPSS 20 программаар гүйцэтгэв.




Figure 2. Cortisol levels in human blood in a standard solution

the formation of a linear equation by dilution

Судалгаанд оролцсон хүмүүсээс нийт 30 цусны дээж авсан. Эдгээр дээжнээс судалгаанаас хасах шалгуурын дагуу 10 хүнийг хассан.

Үүнд:

- Судалгаанд оролцохоос татгалзсан - 1;
- Эмээ тун ёсоор гүйцэд уугаагүй - 3;
- Эм ууж байх хугацаандаа стрессийн эсрэг өөр эм уусан - 2;
- Эм ууж байх хугацаандаа архи уусан – 4 байв.

Тиймээс 20 дээжинд кортизолын хэмжээг шинжилсэн болно.

Table 1. Participated in a clinical observation study human serum cortisol levels (ug/L)

№	Names	Srog 'dzin-5 (a week)		Reduced percentage (%)
		Before use (ug/L)	After use (ug/L)	
1	Teg	186.1	127.9	31.3
2	Utu	194.0	79.4	59.1
3	Bad	142.6	112.6	21.0
4	Ana	145.2	119.9	17.9
5	Esh	161.9	92.4	42.9
6	Ber	215.4	184.3	14.4
7	Alt	138.9	94.7	31.8
8	Bat	131.8	95.2	21.2

9	Ermeg	161.2	127.7	20.8
10	Ankh	127.6	94.4	26.0
11	Gun	79.4	70.3	11.5
12	Khul	77.4	68.9	10.9
13	Byam	93.7	72.2	22.9
14	Od	114.3	80.4	29.6
15	Am	76.5	69.4	9.2
16	Mun	111.6	78.7	29.5
17	Bat	120.5	99.4	24.0
18	Enkh	70.4	61.3	10.5
19	Tur	87.4	78.9	8.9
20	Buu	90.7	69.2	20.9

Хүснэгт 1-ээс харахад эмнэл зүйн ажиглалтын судалгаанд хамрагдсан хүмүүсийн цусны ийлдсэн дэх кортизолын хэмжээ Амь баригч-5 бэлдмэл хэрэглээгүй үед 77.4 ug/L-215.4 ug/L байсан. “Амь баригч-5” бэлдмэл хэрэглэсний дараа эмнэл зүйн ажиглалтын судалгаанд оролцогчдын цусны ийлдсэн

дэх кортизолын хэмжээ 9.2%-с 59.1% хүртэл буурсан үзүүлэлттэй байна. Жишээ нь: Тэг гэдэг хүний хувьд тус бэлдмэлийг хэрэглэхээс өмнө кортизолын хэмжээ 186.1 ug/L байсан бол 7 хоног бэлдмэл уусны дараа цусан дах кортизолын хэмжээ 31.3%-р багассан буюу 127.9 ug/L болсон байна.

Table 2. Blood of participants serum cortisol levels (ug/L)

Group	Number of people surveyed	Average indicator - M (ug/L)	Standard error-m	M±m
<b>Cortisol (ug/L)</b> Before drinking	20	134.8	10.5	<b>134.8±10.5**</b>
After drinking	20	98.0	7.6	<b>98.0±7.6**</b>

\*\*p<0.01, Sig=2.8, бэлдмэл уухаас өмнөх болон уусны дараа судалгаанд хамрагдсан хүмүүсийн цусны ийлдсэн дэх кортизолын хэмжээ нь статистик үнэн магадлалтай байна. Хүснэгт 2-оос үзэхэд эмнэл зүйн ажиглалтын судалгаанд оролцож буй хүмүүсийн цусны ийлдсэн дэх кортизолын хэмжээг нийтэд нь дүгнэхэд бэлдмэл уугаагүй үед дундажаар 134.8 ug/L байснаа 7 хоног бэлдмэл уулгасны дараа 27.3%-иар багассан буюу 98.0 ug/L хүртэл буурсан үзүүлэлттэй байна. Судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд: Амь баригч-5 бэлдмэл нь хүний цусны ийлдсэн дэх кортизолын хэмжээг дундажаар 27.3%-р багасгах эмнэл зүйн үр дүнтэй. Бэлдмэлийг уулгах хугацаанаас хамаараад энэ хувь нэмэгдэх статистик (p<0.01) үнэн

магадлалтай. “Амь баригч-5” бэлдмэл нь эмнэл зүйн ажиглалтын судалгааны үр дүнгээр стресс, депрессийн болон сэтгэцийн эмгэгийн эсрэг фармакологийн үйлдэлтэй гэдэг нь тогтоогдов.

**Дүгнэлт:** Уламжлалт анагаах ухааны практикт 19 дүгээр зууны эхэн хүртэл хэрэглэгддэг байсан Ам баригч-5 эмийг сэтгэл гутрал өвчинд хэрэглэдэг болохыг “Маш гайхамшигт баярын хуримын сан” эмийн судраас олж тогтоон, уг жор нь 5 хөл эмээс бүрдсэн зүрхний өвчин, солиорох хийгээд сэтгэл хямрах, зүрх чичрэх, гуниглан тавгүйтэх, сэтгэл түгшихийг дарах үйлдэлтэй болохыг тодруулан судалгаанд хэрэглэх боломжийг бүрдүүлэв.

**Ном зүй:**

1. Насанцэнгэл Л. Сэтгэл гутрах эмгэгтэй хүмүүсийн амны хөндийн эрүүл ахуйн байдлыг үнэлсэн нь. Инноваци - Шинэ Санаа, Шинэ Нээлт, 2015, 16(9-1)

2. Ц.Алтантуяа, С.Цэцэгмаа, Ш.Болд. Амьтанд үүсгэсэн сэтгэл гутралын эмгэг загварт амь баригч-5 жорын үзүүлэх нөлөө. Монголын эм зүй, эм судлал сэтгүүл. УБ, 2020 №2 (17), 71-78

3. Ц.Алтантуяа, С.Цэцэгмаа, Ш.Болд. Амьтанд үүсгэсэн цочмог стресс, сэтгэл төст авир төрхийн эмгэг загварт амь баригч-5 жорын үзүүлэх нөлөө. Монголын эм зүй, эм судлал сэтгүүл. УБ, 2020 №2 (17), 79-87

4. “Сэтгэцийн эрүүл мэнд” үндэсний хоёр дахь хөтөлбөр. Засгийн газрын 2009 оны 303 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.

5. Эмийн сонгодог (нууц) судраас сэтгэл гутралыг эмчлэх найрлагыг тогтоох, клиникийн судалгаа хийж үр дүнг тооцох” сэдэвт хамтарсан төсөл. УБ, 2019

6. Гэлэн Чойжамц. Анагаах ухааны олон эх сурвалжаас хураасан рашаан зүрхэн, халуун, хүйтний энэлгээг арилгагч маш гайхамшигт баясгалангийн хуримын сан. Модон барын төвөд судар

7. Гэлэн Чойжамц. Анагаах ухааны олон эх сурвалжаас хураасан рашаан зүрхэн, халуун, хүйтний энэлгээг арилгагч маш гайхамшигт баясгалангийн хуримын сан. Модон барын төвөд судар

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:  
МАУА-ийн гишүүн, Академич С.Цэцэгмаа*